

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2023/24/НА-СТА-ТШЗ

Цахим
хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр
аймаг

2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: baranbayarg@audit.gov.mn
Аудитор: С.Батцэцэг
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН "ЗАСАГ"
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР"-ЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.СОДНОМ ТАНАА

2023.02.25 № 39

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

003020169

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,097.0	1,110.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,543.9	5,117.2
	Нийт хөрөнгийн дүн	6,640.9	6,227.5
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,640.6	6,227.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,640.9	6,227.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,362.1	3,069.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,503.9	3,483.3
	Үйл ажиллагааны үр дүн	858.2	-413.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	1.5	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	856.7	-413.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,790.9	6,665.5
	Тайлант оны үр дүн	849.7	-438.2
	Эцсийн үлдэгдэл	6,640.6	6,227.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,040.1	2,963.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,962.3	2,924.5
	Үйл ажиллагааны ЦМГ	77.8	38.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	61.5	28.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.00	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	16.3	10.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	32.9	49.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49.2	59.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,529.1	2,234.0
	Урсгал зардал	1,529.1	2,234.0
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,529.1	2,234.0
	Улсын төсвийн санхүүжих	0.0	0.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,529.1	2,234.0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хүний хөгжилд суурилсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж, олон улсын чанарт нийцсэн төрийн үйлчилгээг иргэдэд мэргэжлийн түвшинд, ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, тасралтгүй хөгжсөн байгууллага байх чиг үүрэгтэй байна” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилтууд

1. “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэх”
2. “Орон нутгийн чиг үүрэг, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах”
3. “Иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлэх, гамшиг, осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлж, нийтийн хэв журмыг сахиулах”

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 28 зорилтын хүрээнд 198 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогчийн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд аудитад баримтлах ерөнхий чиглэл”, МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаал баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-т тусгасан асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг зөрчил илрээгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд 20 гүйлгээ, хөрөнгө зарцуулсан 38 тушаал, нийт ... мянган төгрөгийн ажил гүйлгээг цаг хугацаан нь үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11 дэх заалтыг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тулган баталгаажуулалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүйгээс 337,694.7 мянган төгрөгийн худалдан авалтыг илүү, дутуу бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

..Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 615.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад алдааг залруулсан.

7.1 Залруулсан алдаа:

- Ээлжийн амралтын өмнөх болон дараа сард үүссэн байгаа зөрүүг зардлаар хаасныг залруулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дахь заалтуудыг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 1,336.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,336.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1 албан шаардлага, алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлж байна.

7.2 Төлбөрийн акт

7.2.1 Т.Баясгаланд 134.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2 дах заалтыг тус тус зөрчсөн

7.2.2 "Монголын хөлбөмбөгийн холбоо"-ны чуулга уулзалтад оролцох зардлыг холбоогоос даасан тул томилолтыг давхардуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу томилолтод 188.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын 2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн тус тус зөрчсөн

7.2.3 О.Болормаагийн ээлжийн амралт, цалинд 1,014.0 мянган төгрөгийг давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- **7.3 Албан шаардлага**

7.3.1 Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 12.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2, 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалтыг тус тус зөрчсөн

7.4 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

1.1. Илрүүлэлт

Ажил гүйлгээг өглөг, авлагын дансаар дамжуулан нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, дансны бичилтийг буруу хийсэн /харилцах, зардлын данстай харилцуулсан/ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтыг тус тус зөрчсөн

Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг өглөг, авлагын тооцооны дансаар дамжуулан НББ-д үнэн зөв тусгах

2. **Дотоод хяналттай холбоотой**

2.1. Илрүүлэлт

Барилгын материалын үлдэгдлээр тайлагнасан 2020 оны тамгын газрын пасад болон 2019 оны ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөөний засвар, малын тэжээл, бусад хангамжийн материалын үлдэгдэл болох 2-3 жилийн өмнөх нөөцөлсөн өвс, тэжээлийг зарцуулсан боловч данснаас хасаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтыг тус тус зөрчсөн

Өгсөн зөвлөмж:

Урсгал засварыг шинжтэй ажлыг бараа материалд бүртгэхгүй байх

2.2. Илрүүлэлт

Засаг даргын орлогч, засаг даргын туслах болон тэтгэвэрт гарсан албан хаагч нарт зайлшгүй ажлын шаардлагаар ээлжийн амралт эдлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.8, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн

Өгсөн зөвлөмж:

Удирдлагын дотоод зохион байгуулалтыг сайжруулж, ажиллагсдад хуулийн дагуу ээлжийн амралтыг биеэр болон хэсэгчлэн эдлүүлэх

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж, зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл										
1	ТШЗ	1	0.6	1	0.6						
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	Дүн	1	0.6	1	0.6						
	Санхүүгийн тайлангийн аудитын асуудал										
1	ТШЗ	6	1.3			3	1.3	1	-	2	-

2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	6	1.3			3	1.3	1	-	2	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	3	766.8					2	766.8	1	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	3	766.8					2	766.8	1	-
	НИЙТ ДҮН	10	768.7	1	0.6	3	1.3	3	766.8	3	-